



ХЭНТИЙ АЙМАГ
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 09 сарын 09 өдөр

Дугаар 5/34

Өмнөдэлгэр сум

У.Энх-Өлзийг ажилд томилох тухай

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.2 дах заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 145 дугаар зүйлийн 145.1, 145.2 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дах заалт, Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 240, 241 дугаар тогтоол, байгууллагын дотоод журмын 13.1, 13.4 заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Химийн багшаар ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоогдсон Уртнасангийн Энх-Өлзийг биологийн багш дутагдалтай байгаа байдлыг харгалзан 2024 оны 09 дүгээр сарын 09-ны өдрөөс эхлэн химийн багшаар түр томилсугай.

2. Багш У.Энх-Өлзийгийн үндсэн цалинг хөдөлмөрийн гэрээг үндэслэн 2,520,000 (хоёр сая таван зуун хорин мянга) төгрөгөөр тогтоосугай.

3. Багш У.Энх-Өлзийд Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж, багшийн ёс зүйн болон байгууллагын дотоод дүрэм журмыг чандлан сахиж хариуцлагатай ажиллахыг үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ж.СУГАРРАГЧАА

